

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 516 дугаар зүйлийн 516.2 дахь хэсгийн “50 жил” гэснийг “70 жил” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3, 4 дэх хэсгийг нэмсүгэй:

“3.Хамтын удирдлагын байгууллага батлагдсан төлбөрийн хэмжээнээс хэтрүүлэн төлбөр хураан авсан, батлагдсан төлбөр дээр нэмэлт төлбөр ногдуулсан, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан тайлан, мэдээг заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хамтын удирдлагын байгууллага үйл ажиллагаагаа ашгийн төлөө болгож өөрчилсөн, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль болон хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, зохиогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж үйл ажиллагаа явуулсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэрийг үл харгалзан үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөвшөөрлийг хүчингүй болгож, таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ..дугаар сарын ..өдөр

Улаанбаатар хот

ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2006 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг